




ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

Агентлаг байгуулсан холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	“Агентлаг байгуулах тухай” Засгийн газрын тогтоол 2020.12.16 №222	Дагаж мөрдөх огноо:	
Байгууллагын нэр:	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	Газар, хэлтсийн нэр:	Захиргаа, удирдлагын газар
Албан тушаалын нэр:	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан	Албан тушаалын ангилал:	Төрийн үйлчилгээ ТҮ-7
Шууд харъяалагдах албан тушаалын нэр:	Агентлагийн дарга	Шууд харъяалан удирдах албан тушаалын нэр:	Эм шинжлэх лабораторийн дарга

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, ажлын байранд эрүүл ахуйн холбогдох шинжилгээнүүдийг хийж, үнэлгээ өгөх, санал зөвлөмж өгөх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах,

Албан тушаалын зорилт:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, холбогдох хууль, тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх
- Ажлын байранд эрүүл ахуйн холбогдох шинжилгээнүүдийг хийж, үнэлгээ өгөх, санал зөвлөмж өгөх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
--------	------------------------------------	-------------------------------	--

1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж, зааварчилгаа өгөх; 2.Хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартыг мөрдүүлж ажиллах, түүнд нийцсэн хөдөлмөрийн орчин бүрдүүлэх, үйлдвэрлэлийн аюултай болон хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшинг эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах; 3.Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн талаар эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, санал, зөвлөмж өгөх;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, холбогдох хууль, тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд эрүүл ахуйн холбогдох хэмжилт хийж, үнэлгээ өгөх, тайлан боловсруулах, санал зөвлөмж өгөх; 2.Ажлын байран дахь химийн бодисын сорьцыг стандартад заасан аргачлалын дагуу авч, хэмжээ, агууламжийг тогтоолгох; 3.Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн талаар судалгаа, шинжилгээний ажил хийх;	Ажлын байранд эрүүл ахуйн холбогдох шинжилгээнүүдийг хийж, үнэлгээ өгөх, санал зөвлөмж өгсөн байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах; 3.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны материал, гарын авлага, брошюр, зөвлөмж боловсруулах; 3.3.Удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;	Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна.	Г, Т, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол		Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил		Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй/102/ Байгалийн шинжлэх ухаан /053/, /053101/
Мэргэшил		Мэргэжлийн богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байх
Туршлага		Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно
	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах; боловсруулах, харьцуулалт хийх; - санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;

Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачлагатай ажиллах,
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй, шударга байх;
	Бусад	- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Захиргаа удирдлагын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

Нийт ажилтан, албан хаагчид

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан ажлын хэсгийн ахлагч

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА

...../П.МӨНХЖАРГАЛ/

2023 оны.....сарын.....өдөр

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

...../Ш.ЭНХТУЯА/

2023 оны 11 сарын 24 өдөр